

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2022/248-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сүхбаатар сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
	Утас: 70363040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
	Аудитын менежер: Б.Батмөнх
	Утас: 70363036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
	Аудитор: З.Золбоо
	Утас: 70362442 Цахим хаяг: Zolbooz@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал, дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
3. Аудитын тайлан.....	12
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4. Материаллаг байдал	14
3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8. Аудитын гол асуудал	15
3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.10. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
БНСУ	Бүгд найрамдах Солонгос улс
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СЭА-2022/248-НА - СТА-ТШЗ
танай _____-ны № _____-г

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗООНОЗЫН
ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВИЙН
ДАРГА Н. ЭРДЭНЭБАТ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН МЕНЕЖЕР



Б.БАТМӨНХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	21,834,093.50	22,987,454.50
35	БАРАА МАТЕРИАЛ	21,834,093.50	22,987,454.50
35100	Түүхий эд материал	1,076,989.00	460,000.00
35130	Эм боох материал	1,076,989.00	460,000.00
35400	Хангамжийн материал	20,757,104.50	22,527,454.50
35410	Бичиг хэргийн материал	132,600.00	215,750.00
35420	Аж ахуйн материал	17,624,504.50	19,625,004.50
35440	Түлш, шатах тослох материал	3,000,000.00	2,686,700.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	297,428,273.53	288,136,718.01
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	297,428,273.53	288,136,718.01
39200	Биет хөрөнгө	280,502,096.86	271,312,221.30
39201	Барилга, байгууламж, орон сууц	241,798,553.43	241,798,553.43
39202	Хуримтлагдсан элэгдэл	(16,137,601.68)	(24,206,402.52)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	80,735,000.00	80,735,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(46,625,000.02)	(54,205,000.06)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	131,937,180.45	140,162,480.45
39206	Хуримтлагдсан элэгдэл	(116,144,558.91)	(117,280,470.43)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32,212,390.00	32,212,390.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(28,593,648.97)	(29,147,970.87)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,522,825.92	1,522,825.92
39215	Хуримтлагдсан элэгдэл	(203,043.36)	(279,184.62)
39300	Биет бус хөрөнгө	16,926,176.67	16,824,496.71
39301	Програм хангамж	1,372,400.00	1,372,400.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(886,223.33)	(987,903.29)
39303	Бусад биет бус хөрөнгө	16,440,000.00	16,440,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	319,262,367.03	311,124,172.51
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	319,262,367.03	311,124,172.51
51	Засгийн газрын хувь оролцоо	319,262,367.03	311,124,172.51
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	214,786,273.00	214,786,273.00
51200	Хуримтлагдсан үр дүн	(111,795,643.66)	(119,933,838.18)
51210	Өмнөх үеийн үр дүн	(151,400,955.74)	(111,795,643.66)
51220	Тайлант үеийн үр дүн	39,605,312.08	(8,138,194.52)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	216,271,737.69	216,271,737.69
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	319,262,367.03	311,124,172.51

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН	
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	517,048,681.80	389,703,699.00	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	78,888,056.80	23,150,400.00	
120	Нийтлэг татварын бус орлого	78,888,056.80	23,150,400.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	51,899,700.00	3,931,100.00	
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	26,988,356.80	19,219,300.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	438,160,625.00	366,553,299.00	
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	267,437,200.00	332,250,900.00	
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	267,437,200.00	332,250,900.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	170,723,425.00	34,302,399.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,000,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	143,849,574.00	22,929,399.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	26,873,851.00	10,373,000.00	
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	452,085,012.92	378,518,193.52	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	452,085,012.92	378,518,193.52	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	411,845,012.92	357,678,193.52	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	284,017,784.00	217,365,199.00	
210101	Үндсэн цалин	212,258,713.03	121,885,800.26	
210102	Нэмэгдэл	48,593,970.97	60,448,285.46	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,316,000.00	9,734,615.18	
210104	Урамшуулал	14,849,100.00	25,296,498.10	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,236,600.00	30,132,600.00	
210201	Тэтгэврийн даатгал	15,879,100.00	19,742,100.00	
210202	Тэтгэмжийн даатгал	1,671,500.00	2,078,100.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,008,700.00	3,740,600.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	334,300.00	415,600.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	3,343,000.00	4,156,200.00	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,090,900.00	24,979,000.00	
210301	Гэрэл, цахилгаан	3,690,000.00	2,945,384.00	
210302	Түлш, халаалт	15,734,500.00	19,240,076.00	
210303	Цэвэр, бохир ус	1,666,400.00	2,793,540.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	20,007,550.00	19,449,950.00	
210401	Бичиг хэрэг	3,227,200.00	2,662,800.00	
210402	Тээвэр, шатахуун	12,554,800.00	12,935,400.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,913,000.00	1,968,000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	46,800.00	93,600.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,265,750.00	1,790,150.00	
2105	Нормативт зардал	24,739,399.00	29,972,689.00	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,343,199.00	25,683,189.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,396,200.00	4,289,500.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,242,541.00	10,506,400.00	

210604	Урсгал засвар	14,242,541.00	10,506,400.00
2107	Томилолт, зочны зардал	6,000,000.00	6,000,000.00
210702	Дотоод албан томилолт	6,000,000.00	6,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,450,227.85	1,755,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	184,000.00	184,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	92,000.00	92,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	52,000.00	52,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,800,527.85	1,399,300.00
210807	Газрын төлбөр	13,700.00	13,700.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	308,000.00	14,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,060,011.07	17,516,855.52
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,060,011.07	17,516,855.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,240,000.00	20,840,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,240,000.00	20,840,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	19,600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	40,240,000.00	1,240,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	64,963,668.88	11,185,505.48
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	25,358,356.80	19,323,700.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	25,358,356.80	-
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	-	19,323,700.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	39,605,312.08	(8,138,194.52)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	214,786,273.00	216,271,737.69	(151,400,955.74)	279,657,054.95
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	214,786,273.00	216,271,737.69	(151,400,955.74)	279,657,054.95
4	Тайлант үеийн үр дүн	-	-	39,605,312.08	39,605,312.08
5	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	214,786,273.00	216,271,737.69	(111,795,643.66)	319,262,367.03
6	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	214,786,273.00	216,271,737.69	(111,795,643.66)	319,262,367.03
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	214,786,273.00	216,271,737.69	(111,795,643.66)	319,262,367.03
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(8,138,194.52)	(8,138,194.52)
10	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	214,786,273.00	216,271,737.69	(119,933,838.18)	311,124,172.51

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	438,160,625.00	366,553,299.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	438,160,625.00	366,553,299.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	267,437,200.00	332,250,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	267,437,200.00	332,250,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	170,723,425.00	34,302,399.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	143,849,574.00	22,929,399.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	26,873,851.00	10,373,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	436,485,525.00	362,259,099.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	436,485,525.00	362,259,099.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	396,245,525.00	341,419,099.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	284,017,784.00	217,365,199.00
210101	Үндсэн цалин	212,258,713.03	121,885,800.26
210102	Нэмэгдэл	48,593,970.97	60,448,285.46
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,316,000.00	9,734,615.18
210104	Урамшуулал	14,849,100.00	25,296,498.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,236,600.00	30,132,600.00
210201	Тэтгэврийн даатгал	15,879,100.00	19,742,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,671,500.00	2,078,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,008,700.00	3,740,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	334,300.00	415,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,343,000.00	4,156,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,090,900.00	24,979,000.00
210301	Гэрэл, цахилгаан	3,690,000.00	2,945,384.00
210302	Түлш, халаалт	15,734,500.00	19,240,076.00
210303	Цэвэр, бохир ус	1,666,400.00	2,793,540.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,220,700.00	19,131,200.00
210401	Бичиг хэрэг	2,918,100.00	2,793,950.00
210402	Тээвэр, шатахуун	15,554,800.00	12,222,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,968,000.00	1,968,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	46,800.00	93,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,733,000.00	2,053,550.00
2105	Нормативт зардал	22,815,200.00	31,221,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	19,577,000.00	24,721,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,238,200.00	6,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,529,041.00	10,834,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	383,000.00	328,000.00
210604	Урсгал засвар	14,146,041.00	10,506,400.00
2107	Томилолт, зочны зардал	6,000,000.00	6,000,000.00

210702	Дотоод албан томилолт	6,000,000.00	6,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,335,300.00	1,755,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	184,000.00	184,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	92,000.00	92,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	52,000.00	52,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	685,600.00	1,399,300.00
210807	Газрын төлбөр	13,700.00	13,700.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	308,000.00	14,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,240,000.00	20,840,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,240,000.00	20,840,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	19,600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	40,240,000.00	1,240,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,675,100.00	4,294,200.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,675,100.00	4,294,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,675,100.00	4,294,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,675,100.00	4,294,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,675,100.00	4,294,200.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,675,100.00)	(4,294,200.00)

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/ төгрөгөөр /	
				Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	332,250,900.00	332,250,900.00	-	100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	332,250,900.00	332,250,900.00	-	100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	332,010,900.00	332,010,900.00	-	100.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	207,812,000.00	207,812,000.00	-	100.00
210101	Үндсэн цалин	119,926,600.00	112,332,601.26	7,593,998.74	93.67
210102	Нэмэгдэл	60,194,400.00	60,448,285.46	(253,885.46)	100.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,702,000.00	9,734,615.18	(32,615.18)	100.34
210104	Урамшуулал	17,989,000.00	25,296,498.10	(7,307,498.1)	140.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,132,600.00	30,132,600.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	19,742,100.00	19,742,100.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,078,100.00	2,078,100.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,740,600.00	3,740,600.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	415,600.00	415,600.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,156,200.00	4,156,200.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,979,000.00	24,979,000.00	-	100.00
210301	Гэрэл, цахилгаан	2,663,300.00	2,945,384.00	(282,084.00)	110.59
210302	Түлш, халаалт	20,649,300.00	19,240,076.00	1,409,224.00	93.18

210303	Цэвэр, бохир ус	1,666,400.00	2,793,540.00	(1,127,140.0)	167.64
2104	Хангамж, бараа материалын зардал	19,131,200.00	19,131,200.00	-	100.00
210401	Бичиг хэрэг	2,751,500.00	2,793,950.00	(42,450.00)	101.54
210402	Тээвэр, шатахуун	12,222,100.00	12,222,100.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,968,000.00	1,968,000.00	-	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	163,100.00	93,600.00	69,500.00	57.39
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,026,500.00	2,053,550.00	(27,050.00)	101.33
2105	Нормативт зардал	30,000,000.00	30,000,000.00	-	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,500,000.00	23,500,000.00	-	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,500,000.00	6,500,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,200,600.00	12,200,600.00	-	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,694,200.00	1,694,200.00	-	100.00
210604	Урсгал засвар	10,506,400.00	10,506,400.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	6,000,000.00	6,000,000.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	6,000,000.00	6,000,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,755,500.00	1,755,500.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	184,000.00	184,000.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	92,000.00	92,000.00	-	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	52,000.00	52,000.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,399,300.00	1,399,300.00	-	100.00
210807	Газрын төлбөр	13,700.00	13,700.00	-	100.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	14,500.00	14,500.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	240,000.00	240,000.00	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	240,000.00	240,000.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	240,000.00	240,000.00	-	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	332,250,900.00	332,250,900.00	-	100.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	332,250,900.00	332,250,900.00	-	100.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	332,250,900.00	332,250,900.00	-	100.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	29.00	29.00	-	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	14.00	14.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00	-	100.00

65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	14.00	14.00	-	100.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	10.00	10.00	-	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4.00	4.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		34,302,399.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		34,302,399.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		9,553,199.00
210101	Үндсэн цалин		9,553,199.00
2105	Нормативт зардал		1,221,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		1,221,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		2,928,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		2,928,000.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		20,600,000.00
	Бусад урсгал шилжүүлэг		20,600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал		19,600,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		34,302,399.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		34,302,399.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		22,929,399.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		10,373,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Зоонозын өвчин судлалын төв /цаашид Зоонозын өвчин судлалын төв гэх/-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд бараа материалыг шаардах хуудас үндэслэж олгож байх, төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг бүртгэж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор З.Золбоо гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Зоонозын өвчин судлалын төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Байгалийн голомтод халдварт өвчин болон Зоонозын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх,
- Тархалтыг судлах, уг өвчинтэй тэмцэх ажлыг зохион байгуулах,
- Мэргэжлийн тусламж үйлчилгээ, үзүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэж байна.

Тус төвийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 452,085.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,520.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3,390.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,138.2 мянган төгрөгөөр буюу 2.5 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	21,834.0	22,987.4	1,153.4
Үндсэн хөрөнгө	297,428.3	288,136.7	(9,291.6)
Нийт хөрөнгө	319,262.3	311,124.1	(8,138.2)
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	319,262.3	311,124.1	(8,138.2)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	319,262.3	311,124.1	(8,138.2)

Бараа материалын дансны үлдэгдэл 22,987.4 мянган төгрөг болж өмнөх оноос 1,153.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 56,458.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, аймгийн онцгой комиссоос 19,219.3 мянган төгрөгийн нэг удаагийн хамгаалах хэрэгсэл үнэ төлбөргүй шилжүүлэн авсан болон 74,524.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 514,243.6 мянган төгрөг болж өмнөх оноос 8,225.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 4,294.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, ЭМЯ-аас 3,931.1 мянган төгрөгийн компьютерыг үнэ төлбөргүй хүлээн авч, бүртгэлд тусгаснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 311,124.1 мянган төгрөг болж 8,138.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалжээ.

Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 127,345.0 мянган төгрөгөөр буюу 24.6 хувиар буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, бараа материал буурсантай холбоотой байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал өмнөх оноос 73,566.8 мянган төгрөгөөр буюу 16.2 хувиар буурсан нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардал болон нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал буурснаас голлон шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус газрын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг тус бүр 536,360.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 204,109.6 мянган төгрөгөөр бууруулж, 332,250.9 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь нийт орон тоог 14-өөр бууруулснаас цалин хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ-ийн зардлыг нийт 204,109.6 мянган төгрөгөөр бууруулсан баталснаас шалтгаалсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 332,250.9 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 332,250.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 100.0 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус төвийн нэмэлт санхүүжилтийн дансанд Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/496 тушаалаар нийт 19,600.0 мянган төгрөгийн урамшуулал болон 3,329.4 мянган төгрөгийн илүү цагийн хөлс, аймгийн Засаг даргын 2021 оны А/37 дугаар захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөөс 1,000.0 мянган төгрөг, үйл ажиллагааны орлого 10,373.0 мянган төгрөг зэрэг нийт 34,302.4 мянган төгрөг төвлөрснийг бүрэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайлан орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 Тайлант онд Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/567 дугаар тушаалаар тус төвийн дарга, байгууллагын нягтлан бодогч нарт улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” дүгнэгдсэн гэх үндэслэлээр нийт 2,789.1 мянган төгрөгийн урамшуулал олгох шийдвэр гаргасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх “Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 3 дугаар хавсралтын Эрүүл мэндийн ажилтанд улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын 3.7-д ”

Ажлын үр дүнгийн үнэлгээнээс хамааран дараахь хувь хэмжээгээр сар бүр мөнгөн урамшуулал тооцно: биелэлтийн хувь 90-100, үр дүнгийн үнэлгээ бүрэн хангалттай, албан тушаалын үндсэн цалингаас тооцох хувь 11-20 хувь... " гэж заасантай нийцэхгүй байна.

3.7.2 Үндсэн хөрөнгийн ангилалд ашиглаж байгаа боловч үлдэх өртөг "0" болсон 185,344.4 мянган төгрөгийн, 47 нэр төрлийн хөрөнгийг ашиглаж байгаа нь УСНББОУС-17 "Үндсэн хөрөнгө"-ийн 49 дэх "... дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай" гэсэн заалттай нийцэхгүй байна. Иймд "0" үлдэгдэлтэй хөрөнгийг цаашид ашиглах бол дахин үнэлэх эсвэл акталж устгах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Зоонозын өвчин судлалын төв нь шилэн дансны цахим хуудсанд 149 мэдээлэл байршуулахаас 97 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн бол 53 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт -12 удаа
- Дараа жилийн төсвийн төсөл -1 удаа
- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт - 8 удаа
- Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан -1 удаа
- Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан -1 удаа
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ - 2 удаа
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл-7 удаа
- Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл - 2 удаа

- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг - 2 удаа
- Худалдан авах ажиллагааны тайлан-1 удаа
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл - 2 удаа
- Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр - 2 удаа
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан - 1 удаа
- Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт - 2 удаа
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт - 7 удаа
- Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн - 2 удаа

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх онд өгсөн төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар цалинтай давхардуулан олгосон илүү цагийн хөлсийг нөхөн төлүүлэх 821.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 7,091.9 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгснөөс Шилэн дансны цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	1	821.4	1	821.4	100
Зөвлөмж	2	7091.9	1	7,091.3	50
Нийт дүн	3	7,913.3	2	7,913.3	66.7

Өмнөх аудитаар өгсөн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 дэх заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах, хуулийн хугацаанд мэдээллийг тухай бүр шилэн дансанд байршуулах гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр давтан гаргасан учир уг зөрчилд албан шаардлага бичигдэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 29,690.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 4,333.3 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 1,135.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 1 зөрчилд албан шаардлага, 24,222.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

1. Тайлант онд шинээр бүртгэлд тусгасан тоног төхөөрөмжид 458.8 мянган төгрөгийн элэгдэл байгуулалгүй санхүүгийн тайланд тусгасныг залруулга хийлгэлээ.
2. Нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас шалтгаалан албан хаагчдад 1 дүгээр улирлын үр дүнгийн урамшууллыг давхардуулан тооцож, нийт 3,874.5 мянган төгрөг илүү олгосныг аудитын явцад нөхөн төлүүлсэн тул залруулсан алдаагаар тооцлоо.

4.1 Төлбөрийн акт

1. Хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтад тусгагдсан албан тушаалд хамаарахгүй жижүүр Ц.Нинад 322.7 мянган төгрөг, нягтлан бодогч М.Сэлэнгэд 512.3 мянган төгрөг зэрэг нийт 835.0 мянган төгрөгийн хортой нөхцөлийн нэмэгдэл цалин олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь *“Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”*, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт *“Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгох журам”*-ын 2-д *“Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт”-д багтсан ...албан тушаалын сарын үндсэн цалингийн 10 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдлийг сар бүр олгоно”*, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 дугаар тушаалын хавсралт *“... газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалт”*-ыг зөрсөн ба *“Нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хортой нөхцөлийн нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. Төвийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнагдсан биологич Г.Отгонсүрэн, нягтлан бодогч М.Сэлэнгэ, ариутгагч Э.Оюун-эрдэнэ нарт тус төвийн даргын 2021 оны Б/31 дүгээр тушаалаар тус бүр 100.0 мянган төгрөг, нийт 300.0 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байгаа нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид шагнал олгох нийтлэг журмын 1 дүгээр зүйлийн 1.7 дахь *“Төрийн албан хаагчид энэ журамд заасан мөнгөн шагналаас бусад шагнал олгоход мөнгө дагалдахгүй.”* гэсэн заалтыг зөрчсөн ба *“Нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндэслэлгүй олгосон мөнгөн урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

4.2 Албан шаардлага

3. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс шилэн дансанд мэдээлбэл зохих 149 мэдээллээс 53 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3, 6.4, 6.10 дахь заалтуудыг зөрчсөн ба *“Нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг тогтоосон хугацаанд нь мэдээлж байх албан шаардлага өгөх.

4.3 Зөвлөмж

Аудитаар 2 алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

1. Анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1.1 Илрүүлэлт: Тайлант онд 1,213.0 мянган төгрөгийн худалдан авалтын анхан шатны баримт бөөн дүнгээр шивэгдсэн, 21,771.2 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.1.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь *“Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”*, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь *“Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ”* гэж заасныг зөрчсөн ба *“Нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2.1 Илрүүлэлт: Тайлант онд 1,238.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материалыг тухай бүр бичсэн шаардах хуудсаар бус жилийн эцэст бөөн дүнгээр зарлагадсан байна.

1.2.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан *“Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар”*-ын

3.6 " *Материалын үнэ бүхий зүйлсийг байгууллагын үйлдвэрлэл, дотоод хэрэгцээнд зарцуулах шаардлага гарсан үед уг зүйлийг авч зарцуулах хүн "Шаардах хуудас"-ыг 1 хувь үйлдэж зөвшөөрөл авна. Эд хариуцагч шаардах хуудсыг үндэслэн материал, үнэ бүхий зүйлийг тавьж олгосны дараа агуулахын бүртгэлд бичилт хийж, тайлант хугацаанд нягтлан бодогчид хүргүүлнэ.*" гэж заасныг зөрчсөн ба "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна. Цаашид бараа материалыг зарцуулах тухай бүр албан хаагч тус бүрээр шаардах хуудас үйлдүүлж, холбогдох албан тушаалтнаас зөвшөөрөл авсны дараа олгож байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Сэлэнгэ аймгийн Зоонозын өвчин судлалын төв	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
			Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	6	29,690.5	2	4,333.3	1	1,135.0	1	-	2	24,222.2